



СЭЛЭНГЭ АЙМАГ
ЖАВХЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 07 өдөр

Дугаар А/63

Жаргалант

2020 оны Тээврийн хэрэгслийн техникийн
хяналтын улсын үзлэг явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6а, Авто тээврийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19¹.1, 19¹.3.1, Монгол Улсын Засгийн газрын “Авто тээврийн хэрэгслийг үзлэгт оруулах давтамж, оношлогооны төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай” 2016 оны 213 тоот тогтоол, аймгийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А/04 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын хэмжээнд 2020 оны Тээврийн хэрэгслийн / автомашин, өөрөө явагч механизм, мотоцикл, чиргүүл/ техникийн хяналтын үзлэг явуулах сумын комиссыг доорх бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга:

Ж.Хүрэлбаатар

Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга:

Г.Хүрэлтулга

Татварын Улсын байцаагч

Гишүүдэд

Ц.Дарханбаатар

1 дүгээр багийн Засаг дарга

Б.Түмэнжаргал

2 дугаар багийн Засаг дарга

А.Оюунтөгс

Нягтлан бодогч

П.Буяндэлгэр

Хэсгийн төлөөлөгч

Э.Сод-Эрдэнэ

Цагдаа

2. Сумын тээврийн хэрэгслийн улсын үзлэгийг 2020 оны 05 сарын 13-14-нд явуулах бэлтгэл ажлыг хангуулах, тээврийн хэрэгсэл эзэмшигч иргэд, аж ахуйн нэгж, албан байгууллагыг бүрэн хамруулах үүрэг бүхий ажлыг зохион байгуулах, аймгийн комиссын бүрэлдэхүүн, даатгалын төлөөлөгч нарыг ажлын байр бусад ажиллах нөхцөлөөр хангаж ажиллахыг комиссын дарга /Ж.Хүрэлбаатар/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2019 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн А/22 тоот захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ж.ОТГОНДАЛАЙ.